

БУДДЫН ФИЛОСОФИ ДАХЬ ЯНАГУУХИ ХИЙГЭЭД ҮНЭМЛЭХҮЙ ҮНЭНИЙ ТУХАЙ ҮЗЭЛ САНАА (ЗОНХАВАГИЙН “БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ” ЗОХИОЛООР)

Доктор О. Чимэг

Түлхүүр үг: Хоёр үнэн, мэдэгдэхүүн, “эс үзсэний ёсоор үзэх”, бодат ба зохилдох үнэн, “туурвилын тор”.

Товч утга: Өгүүллийг зохиогч буддын философи дахь хоёр үнэний тухай асуудлыг богд лам Зонхавагийн “Бодь мөрийн зэрэг” зохиолын үзэл санаагаар авч үзэж, хоёр үнэний тухай ойлголт нь хүний танин мэдэхүйн түвшинг илэрхийлэх бөгөөд янагуухи үнэн нь юмс үзэгдлийн мөнх мэт өнгөн талыг, үнэмлэхүй үнэн нь бариад авах юмгүй хоосон мөн чанарыг нь тусган харуулдаг тухай өгүүлсэн болно. Янагуухи үнэн нь “би” хэмээгдэх, өөрийн бэлгэ чанараар бүтсэн зүйл энэ ертөнцөд үгүй байтал буй хэмээн үзэх мунхаг бөгөөд бүхэн худал боловч үнэн мэт үзэгдэх утгаараа “бүхэн худал үнэн” буюу “янагуухи үнэн”, харин үнэмлэхүй үнэн нь аливаа юмс үзэгдэл төдийгүй ерөөс “орон”, “оронт” буюу “объект”, “субъект”-ын аль аль нь өвөрчлөнгөөр үгүй, өөрийн бэлгэ чанараар үгүй болохыг таньж мэдсэн түвшинг илэрхийлсэн ойлголт болно гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Ингэхдээ үнэмлэхүй үнэнд хүрнэ гэдэг нь түүний талаар мэдлэгтэй болох төдийхөн бус, харин бясалгалын эцэст хүрэх ухаарлын үр дүн болох талаас нь ойлгон тайлбарласан. Бодат үнэмлэхүй үнэний “мэдэл” нь ямар нэгэн дүр буюу үг, хэллэгээр үл илэрхийлэгдэх бөгөөд “туурвилын тор” буюу сэтгэхүйн аливаа үйл ажиллагаа зогссон, “юуг ч эс үзсэний ёсоор үзэх” ухаарлын агшин хэмээн дүгнэсэн байна. Мөн үнэмлэхүй үнэний бодат ба зохилдох гэх зэрэг зарим ялгалыг авч үзсэн.

Би үгүйн хоосон чанарыг онох тухай асуудал буддын философийн хоёр үнэний асуудалтай холбогдон тавигддаг. Богд Зонхава “Бодь мөрийн зэрэг” зохиолын хоёр үнэний асуудлыг үлэмж үзэхүйн хэсэгт авч үзэхдээ ертөнц нь янагуухи үнэн (kun rdzob bden pa) хийгээд үнэмлэхүй үнэн (don dam bden pa) бөгөөд мэдэгдэхүүнээрээ /shes bya/ ялгардаг гэж тодорхойлжээ. Тэрээр “хоёр үнэний шүтээн дор урьдтан нугууд дор таалах ёс олон буй боловч үүн дор нь “Сурталыг түгсэн”-ээс” мэдэн үйлдэхүй нь янагуухи хийгээд үнэмлэхүй үнэн дор бариму хэмээн номлосноор мэдэгдэхүүн нь ялгах шүтээн болой” (1,195a) хэмээсэн нь танин мэдэхүйн “объект”-ыг хоёр үнэнийг ялгах шалгуур болгосон хэрэг юм.

Нөгөө талаар янагуухи хийгээд үнэмлэхүй үнэний бэлгэ чанарыг Зонхава”гадаад дотоодын бодас энэ нүгүүд нэжгээд, нэжгээд дор ч үнэмлэхүй утга хийгээд янагуухи чанар” хоёр, хоёр буй буюу. Тэр ч ногоо мэт нэгэн дор үлвээс мэдэгдэхүүн үнэхээр тэр ямагт чанарын утгыг үзэгч ухааны мэдлээр олсон ногооны чанар хийгээд мэдэгдэхүүн худал аргадлын утгыг оносон томъёоны мэдлээр олсон ногооны чанар болой. Түүний урьдахь нь ногооны үнэмлэхүй утга үнэний чанар мөн бөгөөд хойд нь ногооны янагуухи үнэний чанар болой” (1,197b) гэж тодорхойлсноос үзэхэд дээрх хоёр үнэн мэдэгдэхүүн буюу объектыг танин мэдсэн түвшинтэй холбоотой байх ажээ. Янагуухи үнэн нь юмс үзэгдлийн мөнх мэт өнгөн талыг, үнэмлэхүй үнэн нь мөн чанарыг нь танин мэдсэний илэрхийлэл.

*Үнэмлэхүй үнэн (don dam bden pa) хийгээд янагуухи үнэн (kun rdzob bden pa) нь төвд хэлээр дээд утга үнэн, бүхэн худал үнэн гэсэн утгатай бөгөөд ийм нэр томъёог Зонхавын “Бодь мөрийн зэрэг”-ийн орчуулгад хэрэглэсэн нь бий (Ашигласан ном зохиолын жагсаалтын 16). Харин энд илүү түгээмэл хэрэглэгдэж байгааг нь бодолцон үнэмлэхүй хийгээд янагуухи үнэн гэдэг нэр томъёог хэрэглэлээ.

Тэрээр янагуухи хийгээд үнэмлэхүй үнэний бэлгэ чанарыг тодорхойлохдоо Шантидевагийн "Бодхичарьяаватара" ("Бодисадын явдалд орохуй") болон түүний тайлбараас эш татаж тайлбарлахдаа "Ногооны нэгэн чанарыг урьд хойд мэдэл хоёул дор хамаарах хоёр үнэн дор үзүүлсэн бус буюу. "Орохуйн" тайлбараас: хамаг бодасын өөрийн чанар нь хоёр зүйл дор чухал үзүүлсэн бөгөөд энэ мэт буюу. Янагуухи хийгээд үнэмлэхүй утга болой хэмээн бодас нэжгээд нэжгээдийн чанар дор хоёр хоёр ялгаж дээд утгыг нь үнэхээр утгыг үзсэн мэдэл хийгээд янагуухийг нь худлыг үзсэн мэдлээр олох хэмээн номлов" (1,1976-198а) гэж анхааруулжээ.

Янагуухи үнэн нь ном нугууд дор өөрөөсөө бүтсэн өөрийн чанар үгүй бөгөөтөл буй хэмээн гүтгэгч мунхаг үзэлд дулдуйдах ажээ. Kun rdzob bden pa буюу бүхэн худал, эсвэл янагуухи хэмээх үнэн нь ямар утгаар үнэн бэ гэвэл "ном нугууд дор өвөрчлөнгөөр бүтсэн өөрийн чанар үгүй бөгөөтөл буй хэмээн гүтгэгч мунхаг мөн буюу. Утга дор үнэхээр бүтсэн үгүйн тул үнэн дор агуулах оюуны хувьд мөн бөгөөд үнэн баримтлагч бус оюуны хувьд үнэн хэмээн агуулах үгүйн тул болой" (1,1966) хэмээн мунхагаар мөн чанарыг түйтгэрлэсэн тул бүхэн худал боловч үнэн дор үзэгдэх утгаараа "бүхэн худал үнэн" буюу "янагуухи үнэн" хэмээн тайлбарлажээ. "Орохуйн" тайлбарт "хоромхон сансрын гишүүн бээр огоот хураасан нисваанист мунхагийн эрх бээр ианагуухи үнэн" (1,1966) хэмээн агуулдаг байхад "Шравака, пратьекабудда ба бодьсадва нисваанист мунхагийг тэвчээд хуран үүдсэн өнгө хөрөг тэргүүтнийг буй луга адил үзэгч нугууд дор нь засдагийн мөн чанарт" (1,1966) хэмээн энэхүү үнэнийг хуурамч шинж чанартай хэмээн ухаардаг ажээ.

Үнэмлэхүй үнэний бэлгэ чанарыг Зонхава "Бодхичарьяаватара"-гаас эш татан "мэдэгдэхүүн үнэхээрийн утгыг үзсэнээр олсон дор номлосон урьд мэт мөн бөгөөд түүний тайлбараас: түүн дор дээд утга нь үнэхээр айлдагч нугуудын ялгамжаат бэлгэ билгийн оюун (төвд эх дээр "орон" гэж байгаа бөгөөд миний хэрэглэсэн орчуулгад (ашигласан ном зохиолын 16) "оюун" гэж байсан нь зөв байж болох юм-О.Ч) өөрөө бээр өөрийн чанарыг олсон мөн буюу" хэмээн тодорхойлжээ. Гэвч тэрээр энэ ертөнцөд үнэхээр бүтсэн юм огт үгүй гэсэн их хөлгөний баримтлалыг дахин дахин анхааруулж "тэгш агуулсан цуврилгүй бээр олох нэгэн болбоос үнэхээр бүтсэн мөн болой хэмээн өгүүлэхийг хаасан болой" (1,2006) гэжээ.

Нөгөө талаар тэрээр "ялгамжаат бэлгэ билиг хэмээн номлосноор хутагт нугуудын бэлгэ билиг алин буй бээр олж үл болмуй. Ялгамжаат бэлгэ билиг ямар мэтийг айлдсан бэлгэ билгээр олсон нэгнийг үнэмлэхүй үнэн хэмээн үзүүлсэн болой" гэж хэлснийг тайлбарлахын тулд "Бодь мөрийн зэрэг"-т Ji snyed pa буюу эмпирик бодит байдал ба Ji lta ba буюу үнэмлэхүй үнэнийг (Ю.Н.Перих, 3-р боть) илэрхийлэх хоёр нэр томъёо хэрэглэгддэгийг үндэс болгох нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

Үүнээс Ji snyed pa-г хэдийчинээ ба Ji lta ba-г ямар мэт гэж орчуулдаг (16). Ji snyed pa буюу хэдийчинээ нь орчин үеийн философийн тархмал ойлголтоор бүх юмс үзэгдэл гэсэн утгатай, харин Ji lta ba буюу ямар мэт гэдэг нь байгаагаараа гэсэн утгатай бөгөөд буддын философийн "түүнчлэн чанар" гэсэн нэр томъёотой утга ойролцоо юм. Ямар мэтийг олсон ёсыг Зонхава "бүрэлзэхүй нүдтэн бээр завсрын, үзэгдлийн шүтээн дор урт ус цуврихуйг үзсэн дор бүрэлзэхгүй нүдээр тэр шүтээн дор урт ус цуврихын үзэгдлийн төдийхөн ч үл үзэгдэхчлэн мунхагийн бүрэлзэхүй бээр хор үйлдсэн нүгүүд бээр цогц тэргүүтний өөрийн чанар зорьсон түүнийг мунхагийн авъяас хоцролгүй барагдсан хийгээд суралцагч хутагтаны тэгш агуулсан цуврилгүй бэлгэ билгээр тэр ямагт чанарыг айлдахын ёсны эрх бээр болговоос бүрэлзэхгүй нүдчлэнхүү хоёр үзэгдэл нарийныг ч үл үзэхийн ёс бээр алин чанарыг үзсэн нь үнэмлэхүй үнэн буюу" (1,201а) гэж тайлбарлажээ.

Үүнтэй холбогдуулан бурхантны эцсийн зорилго болдог нирвааныг "Ухааны жаран шүлэгтийн" тайлбараас: хэр нирваан ч янагуухи үнэн мөн буюу

хэмээвээс энэ нь түүнчлэн "буюу" хэмээсний утгыг тайлбарлан Зонхава үүгээр "нирваан үнэмлэхүй үнэнийг буй хэмээн агуулах ч янагуухи үнэн, томъёоны мэдэл дор буйн төдийхөн агуулах. Энэ ёс дор нирваан янагуухи үнэн хэмээн таалсан бус буюу" хэмээн нирвааныг үнэмлэхүй үнэн гэж үзэхдээ түүнийг ертөнцөөс тусгаар нэгэн хүрэх цэг, ямар нэгэн "буй юм" гэж үзэж болохгүй хэмээн мөн "Ухааны жаран шүлэгтийн" тайлбараас эш татан: "...буй хэмээн агуулсан бүхэн ертөнцийн томъёоны эрх бээр агуулах буюу. Билиг барамидас: энэ хамаг ном нь ертөнцийн томъёо дор шүтэж нэрийдсэн буюу. Үнэмлэхүй дор бус болой" (1,201б) гэж тайлбарласан байна.

Гэхдээ "алин томъёо дор буй хэмээн агуулах нугууд нэрийн томъёоны эрх бээр буй хэмээн агуулсан мөн боловч түүний эрх бээр алин агуулсан бээр *томъёо дор буй хэмээн үл таалму*" (203а) хэмээн оронтын томъёоны эрхээр агуулсан хэдий ч аливаа юмс үзэгдлийг өөрийн чанараар буй, өвөрчлөнгөөр ба өөрийн бэлгэ чанараар ба өөрийн мөн чанараар буй хэмээн "томъёо дор ч үл таалах буюу" (1,203 а) гэж онцлон тэмдэглэсэн байна.

Энэ санааг тайлбарлахдаа тэрээр гүтгэж, заль зэрэглээ дор шинжилсэн аливаа юмс үзэгдлийг бярман нар ертөнц дор ч буй бус, "томъёо дор ч үгүй" хэмээн номлосон тул оюун андуурсан заримууд (хариуд нь-О.Ч) "буйн төдийхөн бөгөөд инагуухи буй хэмээн өгүүлдэгийг талжурва (прасангика буюу хэтрүүлэгч төв үзэлтэн) нар "зүрхэн үгүй үг" гэж үзэж, бусад их дундадтаны аль ч чиглэл үүнийг хүлээн зөвшөөрдөггүй, "Бодхичарьяаватара"-д "орон, оронт дор буй үгүй тэргүүн адил зохиовч ер буй, үгүйн төдийхөн бус буюу. Тэр хоёр өвөрчлөнгөөр буй, үгүй дор тэр мэт зохиосон болой" (1,203 а) гэжээ.

Үүнд оронт гэдэг нь танин мэдэж буй "субъект" буюу хүн бөгөөд орон гэдэг нь "объект" буюу хүнд хүртэгдэж буй бүх юмс үзэгдэл юм. Харин эдгээрийг зөвхөн хүнд хамаатай, түүнд танин мэдэгдэх утгаар нь хэлж байгаа болно.

Үнэмлэхүй үнэнийг олох, ямагт чанарыг онохуй гэдэг нь бүхний мөн чанарыг танин мэднэ гэсэн үг бөгөөд танин мэдэхүйн энэхүү дээд түвшинг "юуг ч эс үзсэн дор тэр ямагт чанарыг үзэв" (1,203 б), "тэр ямагт чанарыг онохуй дор агуулахуй нь томъёоны мэдлийн төдийхөн дор агуулму. Бэлгэ билиг түүний хувьд үл агуулахын утга мөн" (1,205 б) гэх зэргээр тодорхойлсон нь энэ үед бүхний мөн чанарыг танин мэднэ гэдэг нь бидний ярьж сурснаар бүхнийг агуулна гэх боловч уг чанартаа юмс үзэгдэл юуг ч эс үзэх, юуг ч эс агуулах гэсэн үг юм.

Үнэмлэхүй үнэнийг олж бурхан болох цагт энэхүү үнэмлэхүй үнэний "мэдэл" ямар нэгэн дүр буюу үг, хэллэгээр үл илрэх төдийгүй "юуг ч эс үзсэний ёсоор үзнэ". Энэ тухай "Бодь мөрийн зэрэг"-т: "бурханы ямар мэтийг айлдагч бэлгэ билгээр үнэмлэхүй үнэнийг олох бөгөөс "Орохуйн" тайлбараас: дүр тэр мэтийн чанарыг үзсэн үгүй биш үү? Тиймийн тул ямарваа тэдгээрийг бээр үзмүй хэмээвээс үнэн буй за тийм боловч эс үзсэний ёсоор тэдгээрийг үзсэн болой хэмээн өгүүлэх болой хэмээн юу ч эс үзсэн дор тэр ямагт чанарыг үзэв хэмээн номлоод түүнийг мэдүүлэх дор үнэмлэхүй үнэн, хамгийг айлдагч ямагт чанарыг үзэв хэмээн номлоод түүнийг мэдүүлэх дор үнэмлэхүй үнэн, хамгийг айлдагч бэлгэ билгийн орноос ч хэтрэв хэмээн номлол лугат датсан хийгээд бурханы газар дор сэтгэл, сэтгэлээс гарсны гүйдэл ашид урвасан дор номлосон хийгээд бурхан бээр цогц тэргүүтнийг эс үзвээс арван хүчний үе дор хамаг номыг айлдах хэмээн номлосон луга ямар мэт үл харшилму хэмээвээс эс үзсэний ёс бээр үзэв хэмээсэн нь орон алин буй бүгдийг эс үзсэн дор үл үйлдмү. Мунхагийн бүрэлзэхүйн хүчээр зорьсон энэ нүгүүд тэр ямагт чанар дор буй бөгөөс хутагтаны тэгш агуулсан цуврилгүй бэлгэ билгээр зорих хэрэгтэй бөгөөтөл тэр нүгүүд юуг ч эс үзсэний үүднээс тэдгээрийн тэр ямагт чанарыг үзсэн дор үзүүлсэн мөн буюу. Түрдгэгдэхүүн буй бөгөөс зорилго дор болох бөгөөтөл үл зоригдохын тул түрдгэгдэхүүн хоосон нь онов хэмээн агуулахын тул болой. Үзсэн үгүй нь үзсэний дээд болой хэмээн номлосны утгыг ч түүнчлэн мэдтүгэй. Тэр мэтийг ч "Хураангуйгаас": "өнгө нүгүүдийг үл үзэн, мэдэхүй нугүүдийг үл

үзэн, мэдрэхүй нүгүүдийг ч үл үзээд хуран мэдэхүйг үзэхүй үгүй бөгөөд сэтгэхүйг үл үзэн алин дор танин мэдэхүй хийгээд сэтгэхүй сэтгэлийг үзэхүй үгүй нь номыг үзсэн мөн хэмээн түүнчлэн ирсэн бээр үзүүлэв" (1,203 а-203 б) гэжээ. Үүгээр танин мэдэхүйн туйл болсон илт мэдэл, зөнг харуулсан байна.

Үлэмж үзэхүйн үед мэдээллийг хуримтлуулж түүнийгээ бясалган тунгаадаг, харин тунгааж эзэмшихийн үед энэ мэдээллийн хэрэг үгүй болж, шууд ухаарах буюу илт онох болдог. Үнэмлэхүй үнэний ялгалын талаархи Зонхавагийн өгүүлсэн зүйлээс үзэхэд "бодат үнэмлэхүй үнэн" нь "мэдэгдэхүүн бус" /1,207 б/ буюу түүнд хүрэх нь мэдлэг, мэдээлэл хуримтлуулах үйл явц бус, харин бясалгаж "бие дор илт болгох" бясалгалын туйл бөгөөд "бурхан болсон" хэмээн үхлийг хэлдэг ойлголт ч үүнтэй холбоотой болов уу.

Хэдий тийм боловч мэдлэг, ухааныг ч үнэмлэхүй үнэнд хамааруулдаг ажээ: "орон номын чанар үнэмлэхүй дор болгох хэрэгтэй боловч оронт ухааны мэдлийг ч түүн дор номлосон олон буюу", "үнэхээрийн сонсохуй хийгээд сэтгэх ба бясалгаснаас болсон билиг нүгүүд бүгд ташаа буруу бус оронт мөний тул үнэмлэхүй хэмээдэг бөгөөд энэ нь үнэмлэхүй мөний тул болой хэмээн номлосон мэт болой" (1,207 б).

Ухааны мэдлийг Зонхава:

1)"хутагтаны тэгш агуулсан атгаг үгүй бэлэг билиг хийгээд.

2)Бэлгэ дор шүтэж тэр ямагт чанарыг оносон ухааны мэдэл атгагт тэргүүтэн болой" (1,207 б) хэмээн ялгажээ. Энэ хоёрын эхнийх нь "тэр ямагт чанар дор орохуй дор үнэн хийгээд хоёр үзэгдлийн туурвилыг нэгэн дор хамт өөрийн орон дор таслан чадахын тул бодат үнэмлэхүй" бөгөөд "хамаг туурвилаас нөхцсөн хэмээхийн утга ч тэр болой" (1,208 а) буюу

туурвил хэмээх нь үйл ажиллагаа, буюу нөхцсөн хэмээх нь өнгөрч үгүй болох, даван туулах, дэргэдүүр нь өнгөрөх гэсэн утгатай үг бөгөөд эргэцүүлэх, ургуулан бодох сэтгэхүйн үйл ажиллагаа зогссон байдлыг илэрхийлнэ. Харин хоёрдох нь "өөрийн орон дор үнэн туурвилыг түрдгэн чадавч хоёр үзэгдлийн туурвилыг таслан үл чадахын тул ертөнцөөс нөхцсөн үнэмлэхүй лүгэ дүр даган зохилдохын тул зохилдох үнэмлэхүй болой" (1,208 а) гэжээ. Үүнийг буюу бэлгэ хэмээх өвөрмөц онцлог, нотолгоонд шүтсэн, логик сэтгэлгээнд тулгуурласан аналитик мэдлэг нь ямагт чанар буюу хоосон чанарыг хэдийгээр онож чадах боловч "хоёр үзэгдлийн туурвил"-ыг зогсоох хэмжээнд үл хүрэх учраас бодат "үнэмлэхүй үнэн бус" гэж ойлгож болох юм.

Тийм учраас "ухаанаар шинжилвээс ямагт янагуухи буюу" (1,209 а), "Дундад үзлийн чимгээс": "үнэмлэхүй дор төрөх тэргүүтнийг хаасан үнэхээр янагуухи дор багтсан мөн боловч үнэмлэхүй лүгэ зохилдохын тул түүн дор", өөрөөр хэлбэл үнэмлэхүйд номложээ (1,209 а). Харин "үнэмлэхүй нь бодас буй үгүй тэргүүтэн туурвилын тор бүхнийг тэвчсэн хэмээн номлосны туурвилын тор нь хоёр үнэн "Өөрийн тайлбараас": тиймийн тул тэр хоосон бус, хоосон бус ч бус, буй үгүй бус, үл төрөх бус, төрөх бус хэмээн тэр тэргүүтнийг ялж төгс" номлосон бөгөөд "тэр ямагт нь атгагийн хамаг тороос хагацсан болой хэмээн атгагийн хамаг торыг туурвилын тор хэмээн номлосон мэт мөн бөгөөд тэр ч тэр ямагт чанарыг илт оноход няцахын тул тэр нь бодат үнэмлэхүй" (1,209 б) хэмээн бодож эргэцүүлэх сэтгэхүйн үйл ажиллагааг "туурвилын тор" гэж үзэн бодат үнэмлэхүйд хүрнэ гэдэг нь энэ үйл ажиллагаа зогссон болохыг хэлэх тухай өгүүлжээ. Харин ухааны мэдэл бол янагуухид багтахын сацуу үнэмлэхүйд даган зохилдоно гэсэн дүгнэлт хийж болох юм. Үнэмлэхүй үнэнийг ийнхүү тайлбарлах боловч "мэдэгдэхүүн ч янагуухи хийгээд үнэмлэхүй үнэн үүн дор бариму", "гуравдугаар үнэн алин ч үгүй болой" (1,210 а) хэмээн буддын философийн нийт чиглэлд баримталдаг янагуухи хийгээд үнэмлэхүй үнэнийг тодорхойлохын хамтаар хоёр үнэний ялгалыг сайтар таньж мэдэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байна.

Зонхава "Бодь мөрийн зэрэг" зохиолдоо үнэмлэхүй үнэний олон ялгалын талаар өгүүлсэн байна. 1."Орохуйн" тайлбарт: "Хоосон чанар дор дэлгэрэнгүй

ялгаваас арван зургаан хоосон хийгээд дундач ялгаваас бодас хийгээд бодас үгүй ба өөрийн хийгээд бусдын чанар хоосон бөгөөд дөрөв ба хурааваас бодгаль хийгээд номын би үгүй хоёр дор номлосон мэт болой" (1.207а) гэжээ.

2.Бусад сурвалжуудад бодат үнэмлэхүй хийгээд зохилдох үнэмлэхүй хоёрыг ялгасан байдаг байна. Тухайлбал "Дундад үзэгдэлд: "төрөх үгүй энэ ч үнэмлэхүй лүгэ зохилдохын тул үнэмлэхүй хэмээгдэж бодат нь бус буюу. Бодат дор үнэмлэхүй нь хамаг туурвилаас нөхцсөний тул болой хэмээсэн" (1.204 а) тухай Зонхава өгүүлжээ.

Эртний олон мэргэд үнэмлэхүй үнэнийг ангилж байсан бөгөөд "өнгө тэргүүтнийг хаасан хоосон чанар нь ... үнэмлэхүй үнэн нэрийдсэн янагуухи үнэний бэлгэ чанарт ба хойдыг нь (бодат үнэмлэхүй үнэний тухай өгүүлнэ-О.Ч) оюун алин бээр ч орон дор болгон үл чадахын тул мэдэгдэхүүн бус хэмээн" (1.207 б) таалжээ.

Хоёр үнэний тухай Зонхавагийн үзэл санаанаас дараах дүгнэлтийг хийж байна:"Бодь мөрийн зэрэг"-т аливаа юмс үзэгдлийг зөвхөн хүнд хамаатай, түүнд танин мэдэгдэх утгаар нь авч үзэж байгаа бөгөөд манай философид түгээмэл хэрэглэгддэг нэр томъёогоор энэ үзэл санааг "субъектив идеализм" гэж тодорхойлж болмоор санагддаг. Гэхдээ хувьдаа "субъектив идеализм" гэдгийг "объектив идеализм"-тай сөргүүлэхийг ойлгодоггүй. Учир нь "субъектив идеализм" нь хувь хүний ухамсарт бус, хүн төрөлхтний ухамсар анхдагч гэж үздэг мэт байгаа бөгөөд ингэж ойлгосон тохиолдолд нийт хүнд хүлээн зөвшөөрөгдөж болох, хувь хүний хүслээс үл хамаарах "объектив үнэн" -ийг хүлээн зөвшөөрдөг "объектив идеализм"-аас ялгаагүй болж байгаа юм.

Үүний зэрэгцээгээр "хүний ухамсраас үл хамааран орших" анхдагчийн тухай ойлголт мөн ойлгомжгүй санагддаг. Хүний ухамсар гэдэгт хувь хүний бус, юуны өмнө хүн төрөлхтний ухамсар ойлгогдох мэт. Харин хүн төрөлхтөн үгүй бол түүний ухамсраас "үл хамааран орших" ямар нэгэн анхдагчийн тухай асуудал тавигдах ч үгүй. Тэхлээр анхдагчийн асуудал өөрөө ч "гносеологийн" ойлголт болж таарна. Энэ асуудал танин мэдэхүйн хүрээн дэх анхдагчийн асуудал гэсэн утгаар тавигддаг байж болох юм. Энэ тохиолдолд ч уг асуудал өндөг, тахиа хоёрын аль нь анхдагч вэ гэсэн асуудлаас хэтрэхгүй мэт.

"Бодь мөрийн зэрэг" дэх хоёр үнэний тухай ойлголт нь хүний танин мэдэхүйн түвшинг илэрхийлэх бөгөөд янагуухи үнэн нь юмс үзэгдлийн мөнх мэт өнгөн талыг, үнэмлэхүй үнэн нь бариад авах юмгүй хоосон мөн чанарыг нь тусган харуулна. Янагуухи үнэн нь "би" хэмээгдэх, өөрийн бэлгэ чанараар бүтсэн зүйл энэ ертөнцөд үгүй байтал буй хэмээн үзэх мунхаг бөгөөд бүхэн худал боловч үнэн мэт үзэгдэх утгаараа "бүхэн худал үнэн" буюу "янагуухи үнэн" юм. Харин үнэмлэхүй үнэн нь аливаа юмс үзэгдэл төдийгүй ерөөс "орон", "оронт" буюу "объект", "субъект"-ын аль аль нь өвөрчлөнгөөр үгүй, өөрийн бэлгэ чанараар үгүй болохыг таньж мэдсэн түвшинг илэрхийлсэн ойлголт юм.

Гэхдээ үнэмлэхүй үнэнд хүрнэ гэдэг нь түүний талаар мэдлэгтэй болох төдийхөн бус юм. Бодат үнэмлэхүй үнэн нь үг, хэллэгээр үл илэрхийлэгдэх, сэтгэхүйн аливаа үйл ажиллагаа зогссон ухаарлыг илэрхийлсэн ойлголт юм. Үнэмлэхүй үнэн буюу гүн ухаарлын агшнууд амьдралын явцад тохиолдох бөгөөд "Илт онохуйн чимэг" болон "Далан утгат" зохиолууд дахь нэгэн үзүүрт барилдлагын тухай ойлголт танин мэдэхүйн эдгээр агшнуудыг илэрхийлнэ гэж үзэж байна. (3)

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ:

1. а) Лувсандагва (Зонхава). Гурван төрөлхтний анхааран авах бодь мөрийн зэрэг оршвой. Бээжин бар (Төвд хэл дээр). Цаасны хэмжээ 49.5х9.5. Барын хэмжээ 27х6. Мөрийн тоо 5. хуудасны тоо 223 (Эшлэлийг энэ номоор заав).

б) Лувсандагва (Зонхава), Бага бодь мөрийн зэрэг оршив. Төвдийн Молом равжамба хийгээд Монголын гүүш Наганзуна Жүдва аягаа тахимлиг нарын монгол орчуулгаас хийсэн гар бичмэл (эшлэлүүдэд энэ орчуулгыг голлон тулгуурлав).

2. Гончогжигмэдванбу "Найман бод, далан утгын тийн ялгалыг сайтар номлосон Майдар ламын эш хэмээхүй оршвой" /төвд бар/. Цаасны хэмжээ 60,5 х 10. Барын хэмжээ 55,5 х 8. Мөрийн тоо 7. Хуудасны тоо 22

3. Бодонгууд О. Чимэг "Зонхавын "Бодь мөрийн зэрэг дэх" нийгмийн философийн үзэл санаа" философийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээлийн 2-р бүлгийн 2-р зүйл дэх "Хоёр үнэний тухай асуудал" хэмээх хэсэг. "Зонхавын "Бодь мөрийн зэрэг дэх нийгмийн философийн үзэл санаа" диссертац, УБ, 2001

Ideas of Relative and Absolute Truth in Buddhist Philosophy (on the Basis of "Stages on the Path to Bodhi" by Tsonkapa)

Summary

The article considers ideas of two truths in Buddhist philosophy, relative truth and absolute truth, according to Tsonkapa's "Stages on the Path to Bodhi". Relative truth is the result of ignorance, producing ideas of Ego, Self, which have no corresponding reality. Absolute truth expresses level of mind on which knowledge, that there are no things existing by their own, by their own, by their own quality, is achieved. However, reaching absolute truth doesn't mean just knowledge, but the result of cognition of meditation process. Cognition of "real" absolute truth is not seeing of an image and cannot be expressed by any words, it is the name of resultive moments of cognition, "seeing without seeing", stoppage of all mind activities. In addition, there are taken some differences of absolute truth, such as real at coordinated absolute truth.